



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/105

Чойр

Тусгай зөвшөөрөл шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4, 40.6, 40.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүмбэр сумын Ганзам багт байрлах “Говь чанар” ХХК-ийн “Оргил ундраа” супер маркетэд сул болон өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 2029 оны 03 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгүүдэд тавигдах нөхцөл шаардлагыг бүрэн хангаж ажиллахыг “Говь чанар” ХХК-ийн захирал Д.Мөнхцэцэгт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг), Хөгжлийн Сэдлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Хонгор), Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа), Татварын хэлтсийн дарга (П.Энх-Оюун), Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Байгальсайхан), Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Жамбаасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400244